



136 Page



137 Page



138 Page



139 Page



140 Page

# Даруу бэр Рут

-The kind daughter-in-law, Ruth-

**Тайлбарлагч** Дээр үед, Израилийн Бетлехем хотод айхтар өлсгөлөн болжээ. Бетлехемд амьдарч байсан Елимелех эхнэр, хоёр хүүтэйгээ хамт Моаб уруу нүүжээ. Хэдэн жилийн дараа Елимелех нас баржээ.

**Тайлбарлагч** Хөвгүүд нь том болцгоож, Моаб эмэгтэйчүүдтэй гэрлэжээ. Үүнээс хойш арваад жил өнгөрөв.

**Тайлбарлагч** Гэтэл хоёр хүү нь ч бас өвчнөөр нас барцгаажээ. Ингээд ээж Наоми, хоёр бэр болох Орпа, Рутын хамт үлдэв.

**Тайлбарлагч** Төрсөн нутаг болох Израильд нь өнтэй сайхан жил болж байгааг сонсоод Наоми төрсөн нутгаа ихэд санан буцхыг хүсэв. Одоо ч болтугай төрсөн нутаг уруугаа явъя.

**Тайлбарлагч** Наоми төрсөн нутаг уруугаа явахаасаа өмнө хоёр бэр болох Рут, Орпа хоёрыг дуудав.

**Наоми** Та нар минь төрсөн гэр уруугаа буц даа. Би төрсөн нутаг уруугаа буцах боллоо.

**Тайлбарлагч** Тэр гурав салах болсондоо гуниглан хамтдаа тэврэлдээд уйлцгаажээ. Орпа бэр нь төрсөн гэр уруугаа буцахад, харин сайн бэр Рут хадам ээжээсээ салсангүй. Рут Наомид ингэж хэлжээ.

**Рут** Таны явах газарт би явах болно. Таны Бурхан бол миний Бурхан. Тиймээс намайг яв гэж битгий ятгаач.

**Тайлбарлагч** Ингээд Наоми Рут хоёр хамтдаа Израилийн Бетлехемийг зорин явцгаав. Бетлехемийн хүмүүс Наоми Рут хоёрыг хараад мэл гайхав.

**Хүмүүс** Хүүе, Наоми байна, Наоми мөн үү? Их хөгширсөн байна шүү~

**Тайлбарлагч** Хүмүүс Рутын талаар ч асуужээ.

**Хүмүүс** Ямар даруухан сайн бэр вэ?

**Тайлбарлагч** Тариан талбайгаас ургац хураах цаг болжээ. Хүмүүс ургацаа хураахаар тариалангийн талбай уруу явцгаав. Харин Наоми, Рут хоёрт тариан талбай ч байсангүй, туслах хүн ч байсангүй.

**Рут** Ээж ээ, би талбайд очоод хаягдсан тариан түрүүг түүгээд ирье.

**Тайлбарлагч** Бэр Рут нь идэх хоолоо олохын тулд тариан талбай уруу явжээ.



141 Page



142 Page



143 Page



144 Page



145 Page

**Тайлбарлагч** Рут талбайд ирээд тариан түрүү түүж байлаа. Талбайн эзэн болох Боаз түүнийг хараад:

**Боаз** Тэр эмэгтэйг анх удаа харж байх чинь. Амралтгүйгээр тариан түрүү түүж байхыг харвал их ажилсаг эмэгтэй байх нь.

**Тайлбарлагч** Боаз түүний тухай зарцаасаа асуув.

**Боаз** Тэр залуу эмэгтэй хэн бэ?

**Зарц** Аан, тэр бол хадам ээж Наомигаа дагаад ирсэн моаб эмэгтэй. Нэрийг нь Рут гэдэг.

**Тайлбарлагч** Боаз зарцдаа хэлэв.

**Боаз** “Тариа хураахдаа Рутад зориулж үлдээж байгаарай”

**Тайлбарлагч** Рут гэртээ иржээ. Хадам ээж нь түүнээс:

**Наоми** Хаанаас ийм их тариан түрүү аваад ирэв?

**Рут** Ээж ээ, Боаз гэгч хүний талбайгаас тариан түрүү түүгээд ирлээ.

**Наоми** Өө, Боаз бол манай хамаатны хүн. Цаашид тэнд л очиж тариан түрүү түүж байгаарай.

**Тайларлагч** Рут Боаз хоёр гэрлэхивэл сайхан даа гэж Наоми боджээ.

**Тайларлагч** Өдөр бүр өөрийнх нь талбайд ирж тариан түрүү түүж байгаа Рутад Боаз дурласан байлаа. Ингээд Наоми өөрийн бэр Рутыг Боазтай гэрлэхийг зөвшөөрчээ. Удалгүй Боаз Рут хоёр гэрлэн хуримаа хийлээ. Боаз баян хүн байсан учир хэдэн өдрийн турш найрлав. Олон хүмүүс тэр хоёрыг гэрлэсэнд баярлан баяр хүргэж байлаа.

**Тайларлагч** Бурхан Боаз Рут хоёрыг ерөөгөөд хүүтэй болгожээ. Наоми маш их баярлав. Боаз хүүгээ Обед гэж нэрлэжээ. Обед нь Израиль улсын хамгийн агуу хаан болох Давид хааны өвөө байлаа.